



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/13

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эмчилгээний дэмжлэг хүссэн ходоодны хорт хавдартай, ходоодоо бүрэн тайруулах хагалгаанд орох Галт сумын иргэн С.Жавзандуламд 2,000,000 төгрөг, санхүүгийн дэмжлэг хүссэн ганц бие харж хандах хүнгүй, өрх толгойлосон Улаан-Уул сумын иргэн Б.Наранцэцэг, С.Өлзийжаргал, Ц.Нармандах нарт тус бүр 150,000 төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 2,450,000 (Хоёр сая дөрвөн зуун тавин мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын ерөнхий дансны "Иргэд байгууллагын асуудал шийдвэрлэх зардал"-аас гаргаж зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН